



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/440

Мандалговь

Цагийн хуваарьт өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "л" -ийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, дулааны улирал эхэлж байгаатай холбогдуулан тус аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын ажлын цагийг 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл 08:00-12.30, үдийн цайны цаг 12.30-13.30, 13.30-17:00 цаг болгон өөрчилсүгэй.

Хоёр. Энэхүү захирамжийг иргэд, олон нийтэд сурталчилж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Эрдэнэсүрэн), цагийн хуваарийг мөрдөж, ажлаа төлөвлөж, зохион байгуулахыг сумдын Засаг дарга нар болон төрийн байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

482010400